

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: HOWO-3257 автосамосвалын их засварт шаардлагатай сэлбэг

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012127

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос HOWO-3257 автосамосвалын их засварт шаардлагатай сэлбэг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn цахим хуудсаар дамжуулан эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Борлуулалтын хэмжээ: **2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

2018, 2019 оны санхүүгийн тайланд хийсэн Аудитын байгууллагын дүгнэлтийн эх хувь, эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар хувийг ирүүлэх бөгөөд санхүүгийн тайланг бүгдийг ирүүлэх шаардлагагүй.

Тендерийн хамт **1 300 000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 11:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД-22, Энхтайваны өргөн чөлөө – 98, 406 тоот өрөө, утас: 450060 + 115

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ